

Хотын Соёлын байгууллагын үүсэл

1935-3-8-энд Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх уран сайхны улс төрийн зөвлөл байгуулагдсан.

1938-2-7-энд Ардыг гэгээрүүлэх яамны харьяа уран сайхны улс төрийн зөвлөлийг өргөтгөн Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх уран сайхны хүрээлэн байгуулсан.

1942-9-3-энд мөн хүрээлэнг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх уран сайхны хэргийг эрхлэх газар болгон байгуулжээ.

1945-4-7-өд мөн газрыг Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх урлагын хэрэг хэрэг эрхлэх хороо гэж нэрлэх болгосон.1977 оны байдлаар нийслэл хотын үзвэр үйлчилгээ, соёл спортын газрууд нэг удаа 40000 хүнд үйлчлэх чадалтай юм гэж 1977 онд АИХ-ын депутатуудад зориулж гаргасан танилцуулгад дурдсан байна.

1960-4-27-онд Сайд нарын Зөвлөлийн 135 дугаар шийдвэрээр Улаанбаатар хотын клубийг 1960-6-1-нээ Улаанбаатар хотын соёлын ордон болгон байгуулжээ.1961-5-24-энд Сайд нарын Зөвлөлийн 271 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын соёлын ордонг аж үйлдвэрийн комбинатын клубтэй нэгтгэн, ажилчны соёлын ордон болгож, аж үйлдвэрийн комбинатын дэргэд байгуулсан байна.

1956-5-28-энд Сайд нарын Зөвлөлийн 248 дугаар тогтоолоор одоогийн кино үйлдвэрийн дэргэдэх гэрэл зургийн газрыг өргөтгөж, урлагын хэрэг эрхлэх хорооны харьяанд гэрэл зургийн төв студийг аж ахуйн тооцоон дээр-Гэрэл зургийн мэдээлэл-Эрхлэх тасаг/дотроо сурвалжлагчийн бригадтай/-Хар, цагаан зургийн лаборатори-өнгөт зургийн лаборатори-үзэсгэлэн чимэглэл үйлдвэрлэх тасаг-Гэрэл зургийн архивтайгаар-1956-7-1-нээ байгуулахаар тогтоосон байна.

1956-12-30-анд Сайд нарын Зөвлөлийн 667 дугаар тогтоолоор Соёлын яамны харьяа төв фото студийн өнгөт зургийн тасгийг бүх зүйлийн хамт Улаанбаатар хотын захиргаанд 1957-1-1-нээ шилжүүлжээ.

1973-2-9-энд Сайд нарын Зөвлөлийн 30 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын нүүдлийн киноны захиргааг татан буулгаж Соёлын хэлтэс, номын сан, киноны мэргэжилтэн тус бүр 1, нягтлан бодогч 2, мөнгө үнэт цаасны нярав 1-ийн орон тоог хотын захиргаанд нэмжээ.

1934-6-20-онд улсын номын худалдаа байгуулагдсан байна. 1944-4-28-энд Сайд нарын Зөвлөлийн 54 дүгээр хурлын 17 дугаар зүйлээр 18 аймгийн төв, Улаанбаатар хот, Налайхын үйлдвэр зэрэг 22 газарт номын сан байгуулж, уран Сайханы газарт харьяалуулсан.

-Улаанбаатар хотын музей байрлаж байгаа байшинд нийслэл хүрээг чөлөөлсний дараа ардын нам, засгийн газар ажиллаж байсан